



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Эрүүл мэндийн даатгал, үр дүнд
суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр
нөлөө” сэдэвт аудитын товч тайлан**



2023 он



Увс аймаг дахь Төрийн аудитын газраас “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт аудитыг 2021, 2022 оны үйл ажиллагааг хамруулан хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлж эхлэхдээ аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудын боловсон хүчний нөөц, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамж зэрэг тухайн анхан шатны эмнэлгийн суурь чадамж, нөхцөл боломжийн судалгааг хийж үе шаттайгаар нэвтрүүлэхгүйгээр шууд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог улс орон нутгийн хэмжээнд үр нөлөөтэй жигд нутагшуулан хөгжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз суурийг бэхжүүлэх, нөөц боломжийг нэмэгдүүлэх, боловсон хүчний асуудлыг шийдвэрлэх, ажилтнуудыг чадавхжуулах ажлуудыг бодлогын түвшинд үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөөг Эрүүл мэндийн даатгалын системийн хэмжээнд баталж аймгуудад олгох санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан олгож байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын санд 2021 онд 4,044.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 4,340.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн төлөвлөгөөг 107.3 хувиар биелүүлсэн бол 2022 онд 8,845.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 4,874.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж 2022 оны төлөвлөгөө 3,971.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2022 онд 3,971.0 сая төгрөгөөр буюу 44.9 хувиар тасрахад Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын өмнөх оны гүйцэтгэл 4,340.3 сая төгрөг байхад Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас 2022 оны орлогын төлөвлөлтийг хийхдээ 8,845.9 сая төгрөг байхаар хэт өсгөж төлөвлөсөн нь голлон нөлөөлжээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г баталсан байна.

Уг жагсаалтад оношны хамааралтай 705 бүлэг үйлчилгээг тусгасан байх бөгөөд тухайн эмнэлгийн тусгай зөвшөөрөлд заагдсан үйл ажиллагааны хүрээнд гэрээ байгуулан шаардлага хангасан багц үйлчилгээний төрлийг санхүүжүүлэхээр баталдаг байна. Манай аймгийн хувьд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа 4 эмнэлэг байна. Үүнд: аймгийн Нэгдсэн эмнэлэг 350 багц үйлчилгээ, ЭБАЖИ ХХК-ийн эмнэлэг 29 багц үйлчилгээ, Увс-Мөнхтэнгэр ХХК-ийн “Жаргалан” эмнэлэг 14 багц үйлчилгээ, Зөв онош ХХК-ийн эмнэлэг 26 багц үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан байна.



Сонгон шалгаруулалтыг хийхдээ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмын 5.5-д “Тусгай шаардлагад орон нутгийн хязгаарлагдмал нөөц, боломжийг харгалзан үзэж болно” гэсэн заалтыг баримтлахгүй байна. Оношны хамаарлын бүлгийн кодоор ЭМБ-ын үзүүлэх үйлчилгээг хязгаарлах байдлаар сонгон шалгаруулалтыг хийж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн эмнэлгийн саналыг авахгүйгээр гэрээг шууд байгуулсан талаар аудитын явцад хувийн эмнэлэгт хийсэн уулзалт ярилцлагаар хөндөж байна.

Түүнчлэн батлагдсан үйлчилгээний багцын зарим төрөлд хамаарах тусламж, үйлчилгээ орон нутагт огт тохиолддоггүй, тухайн эмнэлгийн чиг үүрэгтэй хамааралгүй, хамаарах эмчилгээний төрөл нь тухайн багцад ороогүй, тухайн үйлчилгээний багцын тусламж үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай нэмэлт эмч мэргэжилтнийг гэрээний хугацаанд нэмж авч ажиллуулах боломжгүй байгаа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаа иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгийг сонгон үйлчлүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 4.1-д “Сонгон шалгаруулалтыг гурван жилд нэг удаа нэгдсэн журмаар зохион байгуулна” гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг болон хувийн эмнэлгүүдийн сонгон шалгаруулалтыг явуулж “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-г 2022 оны 9 дүгээр сард 3 жилийн хугацаагаар байгуулсан байна.

“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 1.5-д “Энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх нийт хугацаанд жил бүр хийх дүгнэлтэд үндэслэн гэрээний баримт бичигт холбогдох өөрчлөлт хийнэ” гэж заасан байх бөгөөд гэрээ дүгнэх хугацаа болоогүй байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс Эрүүл мэндийн Ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/142 дугаар Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-г дүгнэх, “Даатгалын гэрээг дүгнэх журам”, Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 69 дүгээр тогтоолын хавсралтаар “Хэлтсийн даргын” албан тушаалын тодорхойлолтыг -ын 3 дугаар зорилтын хүрээнд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний хэрэгжилтийг үнэлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, чанарын үнэлгээний тайланг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх, мэдээллээр хангах” гэж заасны дагуу Өрхийн эмнэлэг, сумдын ЭМТ, эмийн сангуудын гэрээг дүгнэсэн байна.

Харин Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 07/1337 дугаар бичгээр аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст “Манай газраас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай 2023 онд тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах, 2022 оны гэрээ дүгнэх ажлыг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэж, төлөвлөсөн боловч 2023 онд хийх гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшний мэдээллийг нягтлах шаардлага гарсан тул Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газартай байгуулсан 2022 оны Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ нь гэрээг дүгнэгдэж, шинэ гэрээ байгуулах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөх болохыг уламжилъя” гэсэн чиглэл ирүүлсний дагуу Өрхийн эмнэлэг, сумдын ЭМТ-ийн 2022 оны гэрээг дүгнээгүй байна.



Эрүүл мэндийн салбарын шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилтийн чухал хэсэг болох Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Тусламж, үйлчилгээний санхүүжилтийн шинэчилсэн жагсаалт, журам, тариф” баталсан бөгөөд энэхүү тогтоолоор батлагдсан шинэчилсэн багцын гол зарчим, өөрчлөлтөд салбарын ачааллаас хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага хуваалцах боломжийг нэмэгдүүлэн сонгон шалгаруулалтад тэнцсэн, даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан бүх эмнэлэг санхүүжилт авах боломж бүрдсэн бөгөөд хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

Амбулаторийн үйлчилгээг зөвхөн төрийн өмчит эмнэлгүүд үзүүлдэг байсныг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нээж өгсөн. Ингэснээр төрийн эмнэлгийн хүлээгдлийг бууруулах, өрсөлдөөнийг дэмжих боломжийг дэмжиж өгчээ.

Гэтэл 2022 оны 9 дүгээр сард ЭМДЕГ-аас сонгон шалгаруулалтыг явуулж гэрээ байгуулахдаа тухайн улсын болон хувийн эмнэлгүүдэд оношны хамааралтай бүлгийн кодоор нь үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг тогтоож өгсөн байна.

Энэ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн эмнэлгүүдийн хувьд ЭМД-ын сангаас олгож байгаа санхүүжилт бодитоор гарч байгаа зардалдаа хүрэлцэхгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа талаар санал хүсэлтийг аудитын явцад хувийн эмнэлгүүдийн зүгээс тавьж байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”-ын 3-д “Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн үед заавал шинэчилнэ”, 3.1.1-д “Албан ёсны статистикаар жилийн инфляцын сүүлийн хоёр жилийн нийлбэр 10 хувиас давсан”, 3.1.2-д “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэн” гэж заасан байхад Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хувьд үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн 2021, 2022 онд ашигтай ажиллаж байгууллагын ажилтнуудын улирлын урамшууллыг бүрэн олгож, 13 дахь сарын цалин олгосон бөгөөд цаашид ажлын гүйцэтгэлтэй уялдсан цалин урамшууллын тогтолцоонд шилжүүлэх ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа, мөн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 2021 онд 2,666.1 сая, 2022 онд 2,100.6 сая төгрөгийн авлагатай байна.

Сумдын анхан шатны эмнэлгүүдийн 2021 оны 4 багц үйлчилгээ, ковид-19 цар тахлын санхүүжилт, 2022 оны нэг иргэнээр тооцсон болон гүйцэтгэлээрх санхүүжилтийг авч байна. Харин сумдын ЭМТ-ийн орны тоо, ажилтны тоо ижил боловч хүн амын тооноос хамаарч нэг иргэнээр тооцсон төсөв болон гүйцэтгэлээр авсан санхүүжилт харилцан адилгүй байна.



Аудитын явцад түүвэр байдлаар зарим суманд очиж уулзалт ярилцлага хийхэд эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцооны дагуу ЭМДҮЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг баталсныг мөрдөж ажиллахад цөөхөн хүн амтай сумдад үр дүн муутай, олон хүн амтай сумдын хувьд үр дүнтэй байна. Тухайлбал: Түргэн, Сагил сумдын хувьд санхүүжилт нь үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхгүй бензин, хоолны, эмийн зардлын өр үүсэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бага хамрагддаг зарим сард ажилтнуудын цалинг тавихад хүндрэл үүсэж байна.

Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээс хойш эрүүл мэндийн байгууллагууд нь үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлээ цахимаар үүсгэж, нэхэмжлэх тогтолцоонд шилжсэн бөгөөд 2021 онд лавлагаа шатлалын төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд шилжсэн бол 2022 оноос анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгчид үе шаттай шилжиж байна.

Мөн 2020 онд эмийн сангууд цахим системд холбогдсон байна. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл нь цахим систем бүрэн нэвтрэх гол хөшүүрэг болсон бөгөөд цаашид эрүүл мэндийн мэдээллийн сан үүсгэх, цахим шилжилт хийх гол алхам тавигдсан байна.

Түүнчлэн 2022 оны 5 дугаар сараас эхэлсэн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багцын дэлгэрэнгүй мэдээллийг эрүүл мэндийн мэдээний санд байршуулан хянах боломжтой болжээ. Цаашид өвчний түүхийг цахимжуулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, ЭМД-ын нэхэмжлэлийн хяналтыг бүрэн цахимжуулах бэлтгэл ажлыг хангах зэрэгт салбарын бодлого чиглэж байна. Аймгийн хэмжээнд 50 гаруй эмийн сан, 4 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, 22 анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллага хоорондоо бодит цагийн горимоор холбогдсон байна.

Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд E-health, E-clinic, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд e-hospital, эмийн сангууд health.gov.mn цахим системийг ашиглан мэдээллээ ирүүлдэг байна.

Мөн ЭМДЕГ-ын зүгээс иргэний тавих хяналтыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2021 оны 388 тоот тогтоолын дагуу иргэдийн авсан тусламж, үйлчилгээндээ үүрэн холбоо болон бусад цахим хэлбэрээр хяналт тавих зохицуулалтын дагуу мессеж үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

Иргэд сонголтоороо мобайл банк, интернэт банк ашиглан E-баримт системээр эрүүл мэндийн шимтгэлээ төлснөөр 15-30 минутад, арилжааны банкаар дамжуулан төлөлт хийсэн тохиолдолд 72 цагийн дотор эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрджээ.



Бодит цагийн горим нь тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан иргэний мэдээллийг цахимд тухайн өдөрт нь оруулахаар, оруулаагүй тохиолдолд нөхөн оруулах боломжгүй байдлаар программчилсан нь орон нутгийн түвшинд цахилгааны саатал үүсэх, интернэт сүлжээ тасрах, зарим сумдад хүн хүчний нөөц боломжоос шалтгаалан оруулж амжихгүй байдал үүсэж санхүүжилт хасагдах асуудал гарч байна. Мөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд ашиглаж байгаа e-hospital программ нь мэдээллийг оруулахад механик ажиллагаа ихтэй, цаг их зарцуулдаг, гацалт ихээр үүсдэг талаар сумдын Эрүүл мэндийн төвүүдэд хийсэн уулзалт ярилцлагаар хөндөгдөж байна.

Даатгуулагч иргэд эрүүл мэндийн шимтгэлээ цахим төлбөрийн баримтын систем E-barimt ашиглан төлж байгаа нь цаг алдахгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдүүлж байгаа хэдий ч Нийгмийн даатгалын байгууллагын байцаагчийн хувьд техник ажиллагааг ихэсгэж, ажлын ачаалал нэмэгдүүлэх асуудал гардаг байна.

Edaatgal гар утасны аппликейшныг сурталчлах ажлын хүрээнд гэрээ бүхий байгууллагуудад мэдээлэл өгч ажиллажээ. Увс аймагт 2021 онд 627 хэрэглэгч, 2022 онд 718 хэрэглэгч гар утасны аппликейшн ашиглаж байна.

Мөн 2021, 2022 онд иргэдийн дунд сурталчилгаа хийх ажлын хүрээнд орон нутгийн телевизд мэдээ, мэдээлэл өгч, мөн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэж, сургалт сурталчилгаа зохион байгуулж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 2021 онд нийт 140 өргөдөл гомдол ирүүлснийг шийдвэрлэж хариуг хүргүүлсэн бол 2022 онд нийт 546 өргөдөл гомдол ирүүлснээс 542 өргөдөл гомдлыг шийдвэрлэж хариуг хүргүүлж, 4 өргөдлийг харьяалах байгууллагад шилжүүлсэн байна. Өргөдөл гомдлыг бичгээр, цахим хэлбэрээр, биечлэн ирж уулзах хэлбэрээр гаргасан байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын хэлтэс нь иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт хийсэн тухайн цаг хугацаанд нь ногдуулалт хийж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2021- 2022 онд 16 иргэний өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд эдгээр өргөдлүүд нь давхардуулж шимтгэл төлөх, регистрийн дугаараа буруу оруулах, данс андуурч төлөлт хийсэн зэргээс шимтгэлээ буцаан авах тухай бөгөөд ирүүлсэн өргөдлийг 100 хувь шийдвэрлэсэн байна.

2021-2022 оны санхүүжилтийн хяналтыг хийхэд ЭМДҮЗ-ийн гаргасан 17 тогтоол, Эрүүл мэндийн сайдын гаргасан 1 тушаал, Засгийн газрын гаргасан 2 тогтоолыг тус тус мөрдөн ажилласан байна. Үүнээс ЭМДҮЗ-ийн 6 тогтоол шинэчлэн батлагдаж өнөөдрийг хүртэл мөрдөн ажиллаж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас гэрээ хийгдсэн оношны хамааралтай бүлгээр сар бүр хийсэн ажлын гүйцэтгэлийн нэхэмжлэлийг илгээж, ЭМДЕГ-ын Мэдээлэл технологийн хэлтсээс санамсаргүй болон зорилтот түүврийн аргаар чанар төлбөрийн хяналтын мэргэжилтнүүдэд түүвэр сонгогддог байна. Сонгогдсон түүврийн дагуу анхан шатны баримтыг эрүүл мэндийн байгууллагуудаас нь татан авч тушаал, шийдвэр, аргачлалд үндэслэн хяналтыг хийж байна. Нэхэмжлэлийн хяналтын мэдээг сар бүр ЭМДЕГ-т тайлагнан ажиллажээ.



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт аудитын товч тайлан

2021 онд гэрээт 72 эрүүл мэндийн байгууллагын 23,059.7 сая төгрөг нэхэмжилснээс 2,252.5 сая төгрөг нэхэмжлэлийн хяналтаар хасагдаж, 20,807.2 сая төгрөгийг олгосон бол 2022 онд 76 эрүүл мэндийн байгууллагын 32,870.6 сая төгрөгийн нэхэмжлэл хүлээн авснаас хяналтаар 1,739.8 сая төгрөг хасагдаж 31,130.8 сая төгрөгийг олгосон байна.

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн нэг гол зорилт нь тусламж, үйлчилгээний чанарт тавих хяналтын тогтолцоог бий болгох байсан бөгөөд үүнд тусламж, үйлчилгээний чанарыг урт хугацаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд хүргэх зорилгоор олон улсын эмнэл зүйн удирдамжид суурилсан тусламж, үйлчилгээ бүрийг хянах шалгуурыг боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг хянахдаа ашиглаж эхэлсэн байна.

Энэхүү хяналтын журам шалгуурыг ЭМДҮЗ-өөр 2021 оны 4-р сард баталж хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2022 оны 8 дугаар сард 12 дугаар тогтоолоор цар хүрээг өргөжүүлжээ.

Тус тогтоол хэрэгжсэнээр эрүүл мэндийн байгууллагуудын иргэд даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээг тогтмол хянаж эхэлсэн бөгөөд, хяналтын үр дүн, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Хяналтын журам нь цахим хяналт, нарийвчилсан хяналт, гэрээний гүйцэтгэлийн хяналт, Эмнэл зүйн аудит, газар дээр очиж хийх хяналт үнэлгээ, чанарын үнэлгээ гэсэн төрлүүдтэй байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөр хяналтын журам”-ын 4.1.1.5-д “Чанар, төлбөрийн хяналтыг хийж нэхэмжлэлийг хянахдаа нэхэмжлэлийн түүврийн хэмжээг тусламж, үйлчилгээний төрөл тус бүрээр тогтоож, түүврийн тохиолдлуудаас шалгуур хангаагүй хасагдлын хувийг тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хугацаанд хамаарах нийт нэхэмжлэлийн эх олонлогт нь ноогдуулах буюу нийт нэхэмжлэлийн мөнгөн дүнгээс хасаж тооцох” гэж заасны дагуу санхүүжилтийг хасаж олгож байна. Энэ нь Эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэлээр санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байх эрсдэл үүсэж байна гэсэн санал хүсэлтийг аудитын явцад төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн холбогдох албан тушаалтнууд уламжилж байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг нь хүсэлт ирүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн санд хяналт шалгалт хийж тусгай зөвшөөрөл хүчингүй болгох, хугацаа сунгах, шинээр эрх олгох ажлыг зохион байгуулж байна.

2021 онд 5 төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн, 2022 онд 10 төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн магадлан итгэмжлүүлэх ажлын анхан шатны бэлтгэлийг хангуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн 2021 онд 11, 2022 онд 16 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 2021 онд 5, 2022 онд 23 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2021 онд 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн
тогтолцоо, үр нөлөө” сэдэвт аудитын товч тайлан

Гүйцэтгэлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар 10 санал хүргүүлсэн.
Үүнд:

1

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулж гэрээг байгуулахдаа тухайн эрүүл мэндийн байгууллагын саналыг тусгаж байх.

2

Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга"-ын 3.3-д “Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар нь суурь тарифыг өөрчлөх шаардлагатай эсэхэд жил бүр дүн шинжилгээ хийнэ” гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг шинэчлэн тогтоох.

3

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөлтийг бодитой хийж байх.

4

E-barimt ашиглан өөрийн харьяалагдах сумыг сонгож эрүүл мэндийн шимтгэлийн төлбөр төлсөн тохиолдолд тухайн даатгуулагчийн орлогыг тухайн суманд нь төвлөрүүлэх.

5

E-barimt ашиглан эрүүл мэндийн шимтгэл төлсөн даатгуулагчийн орлогыг харилцахын системд автоматаар татагддаг болгох.

6

Хууль журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөхөөс чөлөөлөгдсөн болон албан журмын даатгуулагч E-barimt ашиглан эрүүл мэндийн шимтгэл төлөх тохиолдолд шимтгэл давхардаж байгаа талаар санамж өгдөг байх зохицуулалт хийх.

7

Орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг <https://shilendans.gov.mn/> цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах цэстэй болгох.

8

Эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөө, өөрөө эрүүл мэндийн даатгалаа төлдөг иргэдийн хамралтын төлөвлөгөөний биелэлт жил бүр хангалтгүй байдаг манай аймгийн нийт хүн амын 77.9 хувийг эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцдаг иргэд эзэлж, хамралтын төлөвлөгөө биелэлт хангагдахгүй байдаг тул эрүүл мэндийн даатгалын орлого, хамралтыг төлөвлөхдөө тухайн хүн амын төр хариуцах иргэдийг хасаж батлуулах.

9

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19.3 дахь заалтын дагуу Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулж байгаа тул хамтран ажиллах гэрээнд Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг биелүүлэх заалтыг оруулж тусгах.

10

Эрүүл мэндийн даатгалын хуулийн хүрээнд төр хариуцах иргэд хамтын төлбөргүй тусламж үйлчилгээ авдаг бөгөөд тусламж үйлчилгээний зардлыг 100% эрүүл мэндийн даатгалын сангаас гаргуулдаг бөгөөд тухайн бүлгийн иргэдийн авсан зардал нь сангийн дийлэнх хувийг эзэлж сангийн ачааллыг нэмэх, шаардлагагүй хэвтэлтийг үүсгэх, буруу хандлагыг үүсгэж байгаа тул хамтын төлбөртэй болгох.